



2020 оны 11 дүгээр сарын 11
№42 /1144/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын
Их Хурлын
тогтоол**

**Улсын Их Хурлын
гишүүнээс чөлөөлөх тухай**

**Монгол Улсын
Ерөнхийлөгчийн
зарлиг**

**Шүүхийн ёс зүйн хорооны
гишүүний албан тушаалаас
чөлөөлөх тухай**

**Монгол Улсын
Засгийн газрын
тогтоол**

**Монгол Улсын дипломат,
албан гадаад паспорт олгох,
эзэмших, хадгалах журам**

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

460.	Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх тухай	Дугаар 30	2257
------	---	-----------	------

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

461.	Шүүхийн ёс зүйн хорооны гишүүний албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 109	2258
462.	Албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 110	2258

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

463.	Жагсаалт батлах тухай	Дугаар 154	2259
464.	Жагсаалт батлах тухай	Дугаар 175	2260
465.	Журам шинэчлэн батлах тухай	Дугаар 190	2262

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

466.	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан хэлэлцсэн тухай	Дугаар 09	2272
------	---	-----------	------

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 10 дугаар сарын 23-ны өдөр	Дугаар 30	Улаанбаатар хот
--	-----------	--------------------

Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалт, 10.2, 10.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:



1.Долгосүрэнгийн Сумъяабазарыг өөрийнх нь хүсэлтийг үндэслэн Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2020 оны 08 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 109

Улаанбаатар
хот

Шүүхийн ёс зүйн хорооны гишүүний албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүхийн захиргааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон Чимэдрэгзэнгийн Оюунцэцэг, Ванчигдоогийн Жавхлан, Дугарын Сүнжид нарыг Шүүхийн ёс зүйн хорооны гишүүний албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2020 оны 08 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 110

Улаанбаатар
хот

Албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүхийн захиргааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон Норлоогийн Эрдэнэцогтыг Шүүхийн ёс зүйн хорооны дарга, гишүүний албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 04 дүгээр
сарын 29-ний өдөр

Дугаар 154

Улаанбаатар
хот

Жагсаалт батлах тухай

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38.1.13, 2020 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр баталсан Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай болон Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиудыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх улаанбуудайн үр, хүнсний улаанбуудай, бүх төрлийн хүнсний будаа, элсэн чихэр, ургамлын тосны жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД**

Ч.УЛААН

Засгийн газрын 2020 оны
154 дүгээр тогтоолын хавсралт

2020 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 9-НИЙ ӨДӨР БАТАЛСАН ГААЛИЙН БОЛОН НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛИУДЫН ДАГУУ ГААЛИЙН БОЛОН НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ УЛААНБУУДАЙН ҮР, ХҮНСНИЙ УЛААНБУУДАЙ, БҮХ ТӨРЛИЙН ХҮНСНИЙ БУДАА, ЭЛСЭН ЧИХЭР, УРГАМЛЫН ТОСНЫ ЖАГСААЛТ

№	Бүтээгдэхүүний нэр төрөл	БТКУС-ын код	Барааны нэр
1.	Хүнсний улаанбуудай	1001.19.10	Хатуу улаанбуудай
		1001.99.11	Зөөлөн улаанбуудай
2.	Үрийн улаанбуудай	1001.11.00	Хатуу улаанбуудай
		1001.91.10	Зөөлөн улаанбуудай
3.	Бүх төрлийн хүнсний будаа	10.06	Бүх төрлийн цагаан будаа
		1008.10.00	Хальслаагүй гурвалжин будаа
		1104.29.90	Хальсалсан гурвалжин будаа
		1008.29.00	Хальслаагүй шар будаа



		1103.19.00	Жингийн дор хаяж 95% нь 1.25 мм нүхтэй металл утсан шигшүүрээр шигшигдэх хальсалсан шар будаа
		1104.29.90	Хальсалсан бусад шар будаа
		1104.29.10	Арвайн будаа буюу хөц будаа
4.	Ургамлын тос	15.07	Шар буурцгийн тос
		15.08	Газрын самрын тос
		15.09	Чидун жимсний тос
		15.10	
		15.11	Дал модны тос
		15.12	Наранцэггийн үр, мөнхцэцэг, хөвөнгийн үрийн тос
		15.13	Наргил модны самрын тос, дал модны самрын тос, бабасугийн тос
		15.14	Рапс, шаармаг, эсвэл гичийн тос
		15.15	Дээр дурдсанаас бусад ургамлын тос
		1516.20.00	Ургамлын гаралтай химийн хувиргалт хийсэн тос
		1517.90.00	Ургамлын холимог тос
5.	Элсэн чихэр	1701.99.10	Элсэн чихэр

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 05 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 175

Улаанбаатар
хот

Жагсаалт батлах тухай

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 5.1.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Монгол Улсын нутаг дэвсгэрт эргэлтийг зөвшөөрөх, олон улсад бүртгэлтэй тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон тэдгээрийн үндсэн түүхий эдийн жагсаалт”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоолыг нийтээр дагаж мөрдүүлэх ажлыг зохион байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшинд тус тус үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

**УУЛ УУРХАЙ, ХҮНД
ҮЙЛДВЭРИЙН САЙД**

Д.СУМЪЯАБАЗАР



Засгийн газрын 2020 оны
175 дугаар тогтоолын хавсралт

**МОНГОЛ УЛСЫН НУТАГ ДЭВСГЭРТ ЭРГЭЛТИЙГ ЗӨВШӨӨРӨХ, ОЛОН
УЛСАД БҮРТГЭЛТЭЙ ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ
ХЭРЭГСЭЛ БОЛОН ТЭДГЭЭРИЙН ҮНДСЭН ТҮҮХИЙ ЭДИЙН
ЖАГСААЛТ**

№	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон тэдгээрийн үндсэн түүхий эдийн төрөл	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон тэдгээрийн үндсэн түүхий эдийн төрлийн хэлбэрүүд	Код
А	Б	В	Г
Нэг. Тэсэлгээний хэрэгсэл			
1.	Цахилгаан тэслүүр	агшны удаашруулалттай хамгаалалттай газрын тос, хийн цооногийн	3603
2.	Цахилгаан бус тэслүүр	цахилгаан бус тэслүүрийн систем угсрах бэлдэц	3603
3.	Цахилгаан бус тэслүүрийн систем	цооног, шпурын гадаргуугийн холбогч блоктой цооногийн болон гадаргуугийн холбогч блоктой хосолсон	3603
4.	Цочир дамжуулах шижмийн гадаргуугийн удаашруулагч систем	цочир дамжуулах шижмээр холбох цохилтын долгион дамжуулах гуурстай холбогч блоктой	3603
5.	Цахим тэслүүр	утастай утасгүй	3603
6.	Цочир дамжуулах шижим	гадаргуугийн холболтын бага хүчин чадлын өндөр хүчин чадлын газрын тос, хийн цооногийн	3603
7.	Цохилтын долгион дамжуулах гуурс	цахилгаан бус тэслүүрийн систем угсрах бэлдэц тэсэлгээний холболтын шугамын, тэслүүргүй тэсэлгээний холболтын шугамын, тэслүүртэй	3603
8.	Гал дамжуулах шижим	-	3603
9.	Гал дамжуулах шижмийн асаагуур	галын цахилгааны	3603
Хоёр. Тэсрэх бодис			
10.	Цэнэг өдөөх тэсрэх бодисын хэрэгсэл бэлтгэх өндөр хүчин чадалтай тэсрэх бодис	RDX	121-82-4
		TNT	118-96-7
		PETN	78-11-5
11.	Бүүстер	цооног, шпурын чиглэсэн үйлчлэлтэй гадаргуугийн	3602
12.	Перфорацийн цэнэг	газрын тос, хийн цооногийн	3602



13.	Пресплитийн цэнэг	-	3602
14.	Аммонит тэсрэх бодис	боодолтой, хамгаалалттай	3602
15.	Динамит тэсрэх бодис	бортоготой, чичирхийллийн	3602
16.	Гранулит тэсрэх бодис	мөхлөгтэй, задгай	3602
17.	Анфо тэсрэх бодис	энгийн найрлагатай, савлагаатай	3602
		нэмэлт хольцтой, савлагаатай	
		энгийн найрлагатай, задгай	
18.	Эмульсийн тэсрэх бодис	хүнд анфо савлагаатай	3602
		савлагаатай, тэслүүрт мэдрэмтгий	
		савлагаатай тэслүүрт, мэдрэмтгий	
		бус	
		задгай	
		анфогийн хольцтой задгай	
Гурав. Үндсэн түүхий эд			
19.	Аммиакийн шүү	Аммиакийн шүү цэвэр	6884-52-2
			6484-52-2
		Аммиакийн шүү сүвэрхэг	3102-30
			3603

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 05 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар 190

Улаанбаатар
хот

Журам шинэчлэн батлах тухай

Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 17.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Монгол Улсын дипломат, албан гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан хүчинтэй хугацаа нь дуусаагүй байгаа дипломат, албан гадаад паспортын ашиглалтад хяналт тавьж, шинэчлэн баталсан журамд нийцүүлэх арга хэмжээ авахыг Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатарт даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 260 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

**ГАДААД ХАРИЛЦААНЫ
САЙД**

Д.ЦОГТБААТАР

Засгийн газрын 2020 оны
190 дүгээр тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ДИПЛОМАТ, АЛБАН ГАДААД ПАСПОРТ ОЛГОХ, ЭЗЭМШИХ, ХАДГАЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Монгол Улсын дипломат, албан гадаад паспортыг олгох, эзэмших, хадгалах, хүчингүй болгох, устгахтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2.Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг баримтална.

1.3.Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дипломат, албан гадаад паспортыг батлагдсан загварын дагуу хэвлүүлж, тухай бүр гадаад улсын эрх бүхий байгууллагад зохих журмын дагуу хүргүүлнэ.

1.4.Дипломат, албан гадаад паспортыг хэвлүүлэх зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

1.5.Дипломат, албан гадаад паспортыг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгож, бүртгэж, хүчингүй болгоно.

1.6.Дипломат, албан гадаад паспорт нь 5 хүртэл жилийн хугацаанд хүчинтэй байх бөгөөд хүчинтэй хугацааг сунгахгүй.

1.7.Дипломат, албан гадаад паспорт нь Олон улсын иргэний агаарын тээврийн байгууллага (ИКАО)-ын Doc 9303-аар тогтоосон стандартыг хангасан дараах төрөлтэй байна:

1.7.1.цахим төхөөрөмжөөр уншигдах паспорт (MRTD);

1.7.2.иргэний биеийн давхцахгүй өгөгдөл (цээж зураг, гарын хурууны хээ г.м)-ийг агуулсан санах ойтой паспорт (eMRTD).

1.8.Энэ журмын 1.7-д заасан дипломат, албан гадаад паспорт дараах мэдээллийг агуулсан байна:

1.8.1.энэ журмын 1.7.1-д заасан дипломат, албан гадаад паспортад эзэмшигчийн эцэг (эх)-ийн болон өөрийн нэр, иргэний харьяалал, регистрийн дугаар;



1.8.2.энэ журмын 1.7.2-т заасан дипломат, албан гадаад паспортад эзэмшигчийн ургийн овог, эцэг (эх)-ийн болон өөрийн нэр, иргэний харьяалал, регистрийн дугаарыг.

1.9.Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дипломат, албан гадаад паспорт мэдүүлсэн, олгосон, хүчингүй болгосон талаарх мэдээллийг цахим мэдээллийн нэгдсэн санд бүртгэж, хилийн шалган нэвтрүүлэх хяналтын цахим мэдээллийн сүлжээтэй холбогдох мэдээллийг солилцоно.

Хоёр. Дипломат, албан гадаад паспорт олгох

2.1.Дипломат гадаад паспортыг Монгол Улсын дор дурдсан албан тушаалтан, иргэнд олгоно:

2.1.1.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, тэдгээрийн гэр бүлийн гишүүд;

2.1.2.төрийн өндөр албан тушаалын ТӨ-III-ТӨ-ҮI зэрэглэлд хамаарах албан тушаалтан, түүний эхнэр/нөхөр, 18 хүртэлх насны хүүхэд;

2.1.3.төрийн өндөр албан тушаалын ТӨ-IYA-ТӨ-ҮIA зэрэглэлд хамаарах албан тушаалтан, түүний эхнэр/нөхөр;

2.1.4.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд асан болон тэдгээрийн гэр бүлийн гишүүд төрийн тусгай хамгаалалтад байх хугацаанд;

2.1.5.төрийн өндөр албан тушаалын ТӨ-III-ТӨ-ҮI зэрэглэлд хамаарч байсан албан тушаалтан, түүний эхнэр/нөхөрт тухайн албан тушаалын бүрэн эрхийн хугацаатай адил хугацаанд;

2.1.6.гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дипломат албан тушаалтан;

2.1.7.төрийн албаны ТЗ-15, АА-I, ТТ-18 зэрэглэлийн албан тушаалтан түүний эхнэр/нөхөр;

2.1.8.хилийн чанад дахь Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газрын дипломат албан тушаалтан болон тэдгээрийн эхнэр/нөхөр, 18 хүртэлх насны хүүхэд;

2.1.9.Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд, Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин дипломат цолтой иргэн, түүний эхнэр/нөхөр, Засгийн газрын салбарын тэргүүний ажилтны “Хүндэт дипломат” хүндэт тэмдгээр шагнуулсан ахмад дипломат болон түүний эхнэр/нөхөр;

2.1.10.энэ журмын 2.1.1-д заасан албан тушаалтан гадаад улсад зорчиход дагалдан явах төрийн тусгай хамгаалалтын алба хаагч.

2.2.Албан гадаад паспортыг Монгол Улсын дор дурдсан албан тушаалтан, иргэнд энэ журмын 3.7-д заасан паспорт мэдүүлэх эрх бүхий төрийн байгууллагаар уламжлан мэдүүлснээр олгоно:

2.2.1.төрийн албаны АА-2-АА-11 зэрэглэлд хамаарах албан тушаалтан;

2.2.2.төрийн захиргааны албаны ТЗ-6-ТЗ-14 зэрэглэлд хамаарах албан тушаалтан;

2.2.3.шүүгч, прокурор;

2.2.4.сум, дүүргийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга;

2.2.5.аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын орлогч;

2.2.6.төрийн тусгай албан тушаалын ТТ-10-ТТ-17 зэрэглэлд хамаарах албан тушаалтан;

2.2.7.Авлигатай тэмцэх газрын хэлтэс, албаны дарга, ахлах ажилтан, ажилтан, шаардлагатай тохиолдолд туслах ажилтан;

2.2.8.төрийн үйлчилгээний ТҮ-11-ТҮ-12 зэрэглэлд хамаарах албан тушаалтан;

2.2.9.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд гадаадад зорчиход дагалдан явах эмч болон үйлчилгээний бусад ажилтан;

2.2.10.Монгол Улсын олон улсын гэрээ, бусад нөхцөлөөр гадаад улсад энхийг сахиулах үүрэг гүйцэтгэх албан хаагч;

2.2.11.олон улсын Засгийн газар хоорондын байгууллагад удирдах болон гүйцэтгэх албан тушаал эрхлэх Монгол Улсын иргэн, түүний эхнэр/нөхөр, 18 хүртэлх насны хүүхэд;

2.2.12.Хилийн чанад дахь Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газрын үйлчилгээ, техникийн ажилтан, тэдгээрийн эхнэр/нөхөр, 18 хүртэлх насны хүүхэд;

2.2.13.Улсын Их Хурлын гишүүний орон тооны зөвлөх болон туслах;

2.2.14.Засгийн газрын гишүүний орон тооны зөвлөх, туслах, хэвлэлийн төлөөлөгч;



2.2.15.Дэд сайд, Төрийн нарийн бичгийн даргын туслах;
2.2.16.Монгол Улсын Өргөмжит консулаар томилогдсон
Монгол Улсын иргэн;

2.2.17.олон улсын хуваарьт нислэгийн нисэх бүрэлдэхүүн
(нисгэгч, инженер, нислэгийн аюулгүй ажиллагааны байцаагч, бүхээгийн
ажилтан);

2.2.18.төмөр зам, иргэний агаарын тээврийн төрийн өмчит аж
ахуйн нэгжийн гадаад улсад суугаа төлөөлөгчийн газрын үндсэн ажилтан;

2.2.19.энэ журмын 2.1.7-д зааснаас бусад дипломат цолтой
ахмад дипломат болон түүний эхнэр/нөхөр.

2.3.Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв
байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга дипломат гадаад паспорт,
консулын асуудал хариуцсан нэгжийн захирал албан гадаад паспорт
олгох, эсхүл татгалзах асуудлыг шийдвэрлэнэ.

2.4.Дараах тохиолдолд гадаад харилцааны асуудал эрхэлсэн
Засгийн газрын гишүүний гарын үсгээр баталгаажсан зөвшөөрлийг
үндэслэн гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв
байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга дипломат гадаад паспорт,
консулын асуудал хариуцсан нэгжийн захирал албан гадаад паспорт тус
тус олгож болно:

2.4.1.“Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал”-
ын 25.4-т заасныг баримтлан олимп, паралимпийн наадам, олон улс,
тив, дэлхийн спортын тэмцээн, наадамд оролцох зорилгоор гадаадад
зорчих Монгол Улсын үндэсний шигшээ багийн тамирчид, тэдгээрийн
дасгалжуулагч, эмч нарт тэдгээрийг харьяалах төрийн захиргааны төв
байгууллагын хүсэлтийг үндэслэн;

2.4.2.“Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал”-
ын 21.6-д заасныг баримтлан дотоодын үйлдвэрлэл, экспортыг дэмжих
зорилгоор төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлага, Монголын Үндэсний
худалдаа, аж үйлдвэрийн танхимын тэргүүлэгчид гадаад улсад албан
томилолтоор ажиллах шаардлагатай тохиолдолд тэдгээрийг харьяалах
байгууллагын хүсэлтийг үндэслэн;

2.4.3.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга,
Ерөнхий сайдаас дипломат, албан гадаад паспорт олгох талаар ирүүлсэн
албан бичгийг үндэслэн.

2.5.Албан гадаад паспортыг зөвхөн албан томилолтоор зорчиход
хэрэглэнэ.

2.6.Энэ журмын 2.3-т зааснаар дипломат, албан гадаад паспорт олгохоос татгалзсан тохиолдолд тухайн албан тушаалтан, иргэнд албан бичгээр хариу өгнө.

2.7.Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор хугацаатай томилогдсон албан тушаалтны бүрэн эрхийн хугацаа дуусахад 6 сар үлдсэн үед шинээр паспорт олгох тохиолдолд түүний хүчинтэй хугацаа 1 хүртэл жил байна.

Гурав. Дипломат, албан гадаад паспорт мэдүүлэх

3.1.Гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дипломат, албан гадаад паспорт мэдүүлэх хуудас (цаашид “мэдүүлэх хуудас” гэх)-ны загварыг батална.

3.2.Мэдүүлэх хуудас паспорт мэдүүлэгчийн талаар дараах мэдээллийг агуулсан байна:

3.2.1.ургийн овог, эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр;

3.2.2.төрсөн он, сар, өдөр, хүйс, регистрийн дугаар;

3.2.3.цээж зураг (3.5x4.5 см-ийн хэмжээтэй);

3.2.4.албан тушаалын ангилал, зэрэглэл;

3.2.5.дипломат, албан паспорт олгох, эсхүл татгалзах шийдвэрийн хэсэг.

3.3.Дипломат, албан гадаад паспортын мэдүүлэх хуудаст тухайн байгууллагын төрийн захиргааны удирдлагын асуудал хариуцсан нэгжийн дарга гарын үсэг зурж, мэдүүлэх хуудаст дурдсан мэдээлэл, энэ журмын 3.4.2-3.4.5-д заасан баримт бичгийн үнэн зөвийг баталгаажуулна.

3.4.Дипломат, албан гадаад паспорт мэдүүлэхэд дараах баримт бичгийг бүрдүүлж, мэдүүлэх хуудаст хавсаргана:

3.4.1.дипломат, албан гадаад паспорт олгох үндэслэлийг тодорхойлсон энэ журмын 3.7-д заасан байгууллагын албан бичиг;

3.4.2.нийгмийн даатгалын шимтгэл төлсөн талаарх лавлагаа;

3.4.3.тухайн албан хаагчийг албан тушаалд томилсон шийдвэрийн хуулбар (байгууллагын “Хуулбар үнэн” тэмдгээр баталгаажуулан);

3.4.4.тухайн албан тушаалтны албан тушаалын/ажлын байрны тодорхойлолт, ажлын үнэмлэхийн хуулбар;

3.4.5.иргэний үнэмлэхийн хуулбар;



3.4.6.энэ журмын 2.1.1-2.1.7, 2.2.10-2.2.11, 2.2.18-д заасан албан тушаалтан, иргэн дипломат, албан гадаад паспорт мэдүүлэх бол гэрлэлтийн гэрчилгээ, хүүхдийн төрсний гэрчилгээний хуулбар;

3.4.7.энэ журмын 2.4-т заасны дагуу дипломат, албан гадаад паспорт мэдүүлэх бол холбогдох байгууллагын хүсэлт, цагдаагийн байгууллагын тодорхойлолт;

3.4.8.төлбөр төлсөн баримт.

3.5.Дипломат, албан гадаад паспорт мэдүүлэгч энэ журмын 3.4.3, 3.4.6, 3.4.7-д заасан баримт бичиг, мэдээллийг төрийн мэдээлэл солилцооны нэгдсэн системээс авах боломжтой нөхцөлд бүрдүүлэхгүй байж болно.

3.6.Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын консулын асуудал хариуцсан нэгж энэ журмын 2.4-т заасны дагуу дипломат, албан гадаад паспорт мэдүүлэгчийн талаар тагнуул, цагдаа, Авлигатай тэмцэх газар, хил хамгаалах, улсын бүртгэлийн байгууллагаас лавлагаа авч болох бөгөөд дараах баримт бичгийг паспорт мэдүүлэгчээс нэмж шаардаж болно:

3.6.1.гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх үндэслэлгүй болохыг нотолсон лавлагаа;

3.6.2.Төрийн албаны зөвлөлийн холбогдох лавлагаа;

3.6.3.төрийн албан хаагчийн тангаргийн хуулбар.

3.7.Дипломат, албан гадаад паспортыг дараах төрийн байгууллага мэдүүлнэ:

3.7.1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон төрийн захиргааны төв байгууллагын төрийн захиргааны удирдлагын асуудал хариуцсан нэгж;

3.7.2.Үндсэн хуулийн байгууллага болон хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллага, Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог байгууллагын захиргааны асуудал хариуцсан нэгж;

3.7.3.Монгол Улсын Ерөнхий сайд, Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын агентлаг нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газраар уламжлан;

3.7.4.энэ журмын 3.7.3-т зааснаас Засгийн газрын бусад агентлаг харьяалагдах төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн даргаар уламжлан;

3.7.5.аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба, Засаг даргын Тамгын газар;

3.7.6.сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба, Засаг даргын Тамгын газар нь энэ журмын 3.7.5-д заасан байгууллагаар уламжлан;

3.7.7.энэ журмын 2.2.10, 2.2.11-д заасан албан тушаалтан, иргэн Монгол Улсын хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газраар уламжлан;

3.7.8.энэ журмын 2.2.16-д заасан олон улсын хуваарьт нислэгийн нисэх бүрэлдэхүүнийг зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар уламжлан.

3.8.Дипломат, албан гадаад паспорт мэдүүлэхэд шаардлагатай нийт баримт бичгийг бүрдүүлсэн мэдүүлгийг хүлээн авсан өдрөөс ажлын 5 хоногт багтаан олгоно.

3.9.Дипломат, албан гадаад паспорт мэдүүлсэн баримт бичгийг гадаад харилцааны төв архивт 10 жил хадгална.

3.10.Дипломат гадаад паспортад гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга, түүний эзгүйд консулын асуудал хариуцсан нэгжийн захирал гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулна.

3.11.Албан гадаад паспортад гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын консулын асуудал хариуцсан нэгжийн захирал, түүний эзгүйд дэд захирал гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулна.

Дөрөв. Дипломат, албан гадаад паспорт эзэмших, хадгалах, тайлагнах, хүчингүй болгох, устгах

4.1.Дипломат, албан гадаад паспорт мэдүүлсэн байгууллагын холбогдох газар, нэгжийн албан тушаалтан дараах үүрэгтэй:

4.1.1.тухайн албан тушаалтан ажлаас чөлөөлөгдөх, халагдах шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор тухайн дипломат, албан гадаад паспортыг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүчингүй болгуулахаар мэдэгдэх;



4.1.2.төрийн албан хаагчийг Төрийн албаны тухайн хуулийн 44.1-д заасны дагуу өөр албан тушаалд шилжүүлсэн, сэлгэн ажиллуулсан тохиолдолд энэ талаар шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор дипломат, албан гадаад паспорт эзэмшигчийн талаар мэдээллийг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэх;

4.1.3.алдагдсан, гээгдүүлсэн дипломат, албан гадаад паспортын талаар 14 хоногийн дотор гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад албан бичгээр мэдэгдэх;

4.1.4.жил бүрийн 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор дипломат, албан гадаад паспорт эзэмшигчдийн талаар тайланд тусган гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлэх.

4.2.Дипломат, албан гадаад паспорт эзэмшигч нь дараах үүрэгтэй:

4.2.1.дипломат, албан гадаад паспортаа хаяж үрэгдүүлсэн, гэмтээсэн тохиолдолд гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын консулын асуудал хариуцсан нэгжид нэн даруй мэдэгдэх;

4.2.2.дипломат, албан гадаад паспорттай зураг, бичлэгээ олон нийтийн аливаа сүлжээнд байршуулахгүй байх;

4.2.3. хилийн чанадад зорчиход паспортын хүчинтэй хугацаа доод тал нь 6 сар байх шаардлагатайг анхаарах;

4.2.4.энэ журмын 4.5-д заасны дагуу эзэмшигч нь Монгол Улсын хилээр орж ирсэн даруйд улсын хил хамгаалах байгууллагад албан гадаад паспортаа хураалгах үүрэгтэй бөгөөд зөрчсөн тохиолдолд дахин албан гадаад паспорт олгохгүй байх үндэслэл болно.

4.3.Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын консулын асуудал хариуцсан нэгж дипломат, албан гадаад паспортыг хадгалах, хүчингүй болгох талаар дараах эрхтэй:

4.3.1.энэ журмын 4.1.1-д заасан дипломат, албан гадаад паспортыг хүчингүй болгох, устгах;

4.3.2.энэ журмын 4.1.4-д заасан тайлан ирүүлж, баталгаажуулаагүй дипломат, албан паспортыг хүчингүй болгох;

4.3.3.улсын хил хамгаалах байгууллагаас хилийн боомтод энэ журмын 4.5-д заасны дагуу хураагдсан дипломат, албан гадаад паспортыг хүлээн авч хадгалах;

4.3.4.энэ журмын 4.3.3-т заасны дагуу хадгалагдаж байгаа паспортыг тухайн албан тушаалтан, иргэн гадаад улсад зорчих шаардлагатай үед тэдгээрийн хүсэлт буюу харьяалах байгууллагын хүсэлтийг үндэслэн холбогдох бүртгэлийг хөтөлж, паспорт эзэмшигчийн гарын үсгээр баталгаажуулсны дараа нэгжийн удирдлагын зөвшөөрлөөр паспортыг түр олгох;

4.3.5.дипломат, албан гадаад паспортыг хүчингүй болгосон тухай шийдвэрийг гадаад улсын Дипломат төлөөлөгчийн газар, хилийн шалган нэвтрүүлэх асуудал хариуцсан байгууллагад мэдэгдэх.

4.4.Алдагдсан, гээгдүүлсэн дипломат, албан гадаад паспортын талаар дараах мэдээллийг Олон улсын эрүүгийн цагдаагийн байгууллага (Интерпол)-ын мэдээллийн санд байршуулна:

4.4.1.дипломат, албан гадаад паспортын дугаар;

4.4.2.энэ журмын 1.9-д заасан мэдээлэл.

4.5.Улсын хил хамгаалах байгууллага дараах үүрэгтэй:

4.5.1.энэ журмын 2.1.1-2.1.9, 2.2.15-2.2.17, Монгол Улсын хилийн тухай хуулийн 23.1-д зааснаас бусад албан тушаалтан, иргэний дипломат, албан гадаад паспортыг Монгол Улсын хилээр орж ирсэн даруйд хилийн боомтод хураан авч, гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хадгалуулахаар шилжүүлнэ;

4.5.2.энэ журмын 4.3.1-4.3.2-т заасан үндэслэлээр хүчингүй болгосон дипломат, албан гадаад паспортыг хүчингүй болгох буюу устгуулахаар шилжүүлнэ.

4.6.Хүчингүй болгосон дипломат, албан гадаад паспортыг жил бүрийн эцэст гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн даргын шийдвэрээр устгана.

4.7.Хүчингүй болгосон дипломат, албан гадаад паспортыг эзэмшигч хүсэлт гаргасан тохиолдолд тухайн паспортод тусгай тэмдэглэгээ хийн дурсгал болгон өгч болно.

Тав. Хяналт, хариуцлага

5.1.Дипломат, албан гадаад паспортын олголтод гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан нэгж хагас жил тутамд эрсдэлийн үнэлгээ хийнэ.



5.2.Дипломат, албан гадаад паспортын олголтын тайланг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын консулын асуудал хариуцсан нэгж хагас жил тутам гаргаж, гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, дэд сайд, гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн даргад тус тус танилцуулна.

5.3.Дипломат, албан гадаад паспорт мэдүүлэхдээ мэдүүлэгч нь баримт бичиг хуурамчаар үйлдсэн, худал мэдээлэл өгсөн, паспортаа бусдад ашиглуулсан, худалдсан, барьцаалсан асуудлыг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрх бүхий байгууллагад шилжүүлж, шийдвэрлүүлнэ.

5.4.Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын консулын асуудал хариуцсан нэгж энэхүү журмын 4.1.3, 4.2-т заасан үүргээ биелүүлээгүй албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах саналаа холбогдох байгууллагын эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх бөгөөд эрх бүхий албан тушаалтан нь сахилгын шийтгэл ногдуулсан эсэх талаар хариу мэдэгдэнэ.

5.5.Энэ журмын дагуу дипломат, албан гадаад паспорт эзэмшиж буй төрийн жинхэнэ албан хаагч гадаад улсын хил, гаалиар болон нутаг дэвсгэрт мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг нэвтрүүлсэн, нэвтрүүлэхийг завдсан, тээвэрлэсэн, хууль бусаар худалдах үйл ажиллагаанд оролцсон талаар гадаад улсын эрх бүхий байгууллагаас дипломат шугамаар мэдэгдсэн тохиолдолд тухайн албан хаагчид Төрийн албаны тухай хуулийн 48.1.3-т заасан сахилгын шийтгэл ногдуулна.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2020 оны 10 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 09

Улаанбаатар
хот

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан хэлэлцсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн
хуралдааны танхим 12.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Одбаяр даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Ш.Цогтоо, Г.Туулхүү, Ш.Солонго, Ц.Нанзаддорж /илтгэгч/ нарын

бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Б.Мөнгөн-Аргамжийг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн Р.Мөнхбат, Б.Цэцэнбилэг болон Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн эсэх; мөн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 9, 18 дахь заалтыг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 16 дугаар хорооны оршин суугч, иргэн Н.Түмэнбаяр, Баянзүрх дүүргийн 26 дугаар хорооны оршин суугч, иргэн Г.Алтаншагай нар Үндсэн хуулийн цэцэд хандан:

“Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт “18 нас хүрсэн, тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэгт санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө байнга оршин суугчаар бүртгүүлсэн, сонгуулийн эрх бүхий, энэ хуульд заасан бусад шаардлагыг хангасан иргэн тухайн шатны Хурлын Төлөөлөгчөөр сонгогдох эрхтэй.” гэж заасан нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн, “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно;”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэсэн хэсгүүдийг тус тус зөрчсөн гэж үзэж байна.

1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт тухайн орон нутагт санал авах өдрөөс өмнө 180-аас доошгүй хоногийн хугацаанд байнга оршин сууж, түүнийгээ албан ёсоор хаягийн бүртгэлд бүртгүүлсэн Монгол Улсын иргэн сонгогдох эрхтэй байхаар хуульчилжээ.



Мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт “Орон нутгийн Хурлын ээлжит сонгуулийн санал авах өдөр нь ээлжит сонгуулийн жилийн 10 дугаар сарын эхний хагасын аль нэг ажлын өдөр байна.” гэж зааснаас үзэхэд нэр дэвшигч нь ойролцоогоор тухайн сонгуулийн жилийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс оройтохгүйгээр тухайн орон нутагт байнга оршин суугчаар бүртгүүлсэн байхаар байна. Гэвч Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч нь сонгууль болохоос хамгийн багадаа 180 хоногийн өмнө багтаж шилжилт хөдөлгөөн хийх ёстой атал ийм боломжгүй байна.

Учир нь 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр батлагдсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт “Иргэний засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөнийг ээлжит сонгуулийн жилийн 02 дугаар сарын 01-ний өдрөөс, ээлжит бус, нөхөн, дахин сонгууль явуулах тухай эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан бол уг шийдвэрийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлсэн өдрийн дараах ажлын өдрөөс эхлэн зогсоож, санал авах өдрийн дараах өдрөөс сэргээнэ.” гэж заасан нь орон нутгийн сонгуульд Үндсэн хуулиар баталгаажсан сонгогдох эрхээ эдлэх иргэний субъектив эрхийг зөрчжээ.

2.Орон нутгийн сонгуульд нэр дэвшин оролцох иргэд хуулийн дагуу шилжилт хөдөлгөөн хийлгэх эрхгүй болсноор Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан тэгш байдал, шударга ёсны зарчим алдагдаж байна. Өөрөөр хэлбэл, өмнө батлагдсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар сонгуулийн жилийн 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн иргэний шилжилт хөдөлгөөнийг Улсын Их Хурлын сонгууль дуустал зогсоосон байтал хууль тогтоогчийн зүгээс 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийг батлахдаа хүний эрхийг зөрчсөн, шударга ёс, тэгш байдлыг алдагдуулсан заалтыг оруулснаараа төрийн үйл ажиллагааны хууль дээдлэх зарчмыг алдагдуулсан байна.

3.Орон нутгийн сонгуульд нэр дэвшин оролцох иргэд нь 180 хоногоос өмнө нэр дэвших шийдвэрээ гарган шилжилт хөдөлгөөн хийлгэхээр болоход хууль зүйн хувьд боломжгүй болж байгаа нь өмнө тухайн орон нутагт байнга оршин суугчаар бүртгүүлчихсэн байсан иргэдэд л зөвхөн сонгуульд нэр дэвших бололцоог олгосон байна. Энэ нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн хүн бүр хуулийн өмнө тэгш байх зарчмыг алдагдуулсан байна.

4.2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр батлагдаж, 12 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсөн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн иргэний шилжилт хөдөлгөөнийг зохицуулсан зохицуулалт нь 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр батлагдаж, 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн шилжилт хөдөлгөөн хийх зохицуулалттай зөрчилдсөн байна. Төр нь хүний эрхийг хамгаалах

үндсэн механизм болохын хувьд Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн хүний үндсэн эрх, эрх чөлөөг хангах хууль зүйн баталгааг бүрдүүлэх ёстой атал сонгогдох эрхийг хангахуйц хууль зүйн баталгаа бүрдүүлж чадсангүй.

Иймд Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх талаар дүгнэлт гаргаж өгнө үү.” гэсэн агуулгатай мэдээллийг ирүүлжээ.

Хоёр. Нийслэлийн Хан-Уул дүүргийн 18 дугаар хорооны оршин суугч, иргэн Р.Мөнхбат, Баянгол дүүргийн 4 дүгээр хорооны оршин суугч, иргэн Б.Цэцэнбилэг нар Үндсэн хуулийн цэцэд хандан:

“Монгол Улсын иргэн хуульд заасан нөхцөл, журмын дагуу сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох, сонгогдох эрхийг хэрэгжүүлэхэд тусгайлсан хуулиар зохицуулах бөгөөд ийнхүү зохицуулахдаа энэхүү эрхийг зөрчих хуулийн зохицуулалтыг оруулахгүй байх шаардлагатай билээ. Улсын Их Хурлаас 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт зааснаар 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл байнга оршин суух хаягаа солих хүсэлтэй иргэдийн шилжилт хөдөлгөөн хийх боломжгүй болсон.

Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр баталсан Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт “18 нас хүрсэн, тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэгт санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө байнга оршин суугчаар бүртгүүлсэн, сонгуулийн эрх бүхий, энэ хуульд заасан бусад шаардлагыг хангасан иргэн тухайн шатны Хурлын төлөөлөгчөөр сонгогдох эрхтэй” гэж заасан. Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 2 дахь хэсэгт аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн санал авах өдрийг 2020 оны 10 дугаар сарын 15-ны өдөр байхаар тогтоосон. Дээрх хуулийн заалтын дагуу аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн санал авах өдрөөс 180 хоногийг ухраан тооцож үзвэл Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт заасан ёсоор сонгуульд нэр дэвших хүсэлтэй иргэн өөрийн нэр дэвших гэж буй аймаг, нийслэл, сум, дүүрэгт 2020 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн дотор байнга оршин суугчаар бүртгүүлсэн байх ёстой буюу дээрх шаардлагыг хангасан иргэн тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид нэр дэвших эрхтэй болохоор хууль тогтоогч зохицуулсан. Гэтэл Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт зааснаар 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл шилжилт хөдөлгөөнийг зогсоосон учир Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт заасан



ёсоор 180 хоногийн өмнө бүртгүүлэх хууль зүйн боломжгүй болж иргэдийн Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад заасан сонгох, сонгогдох эрх зөрчигдөхөд хүрч байна.

“Төрийн үйл ажиллагааны хууль дээдлэх үндсэн зарчим” гэдгийг нийгмийн харилцааг хууль тогтоомжоор зохицуулах, тэдгээр хууль тогтоомж нь Үндсэн хуульд нийцсэн байх, хууль тогтоох болон бусад засаглалууд Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад хуулиудыг гуйвалтгүй сахин биелүүлэх, мөн зөв хэрэглэх гэж ойлгож болно. Улсын Их Хурал хууль батлахдаа хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой нийцүүлэх, батлан гаргасан хууль тогтоомж нь хэрэгжихэд бусад хууль тогтоомжтой нийцтэй, хүний эрхийг зөрчихгүй байх, заавал хэрэгжих шаардлагуудыг бүрэн хангасан байх шаардлагатай. Гэтэл Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт “Иргэний засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөнийг ээлжит сонгуулийн жилийн 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн зогсоож, санал авах өдрийн дараах өдрөөс сэргээнэ.” хэмээн зааснаар Улсын Их Хурлын сонгуульд хамааралтай иргэдийн шилжилт хөдөлгөөнийг аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд давхар хамааруулан иргэдийн эрхийг хязгаарлах үр дагаварт хүргэж байна.

Ийнхүү хуулийн уялдаа холбоог хангаагүйгээс Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн дагуу тухайн орон нутагт байнга оршин суугчаар 180 хоногийн өмнө бүртгүүлэх гэхэд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн зохицуулалтаар бүртгүүлэх боломжгүй болж орон нутгийн сонгуулийн санал авах өдрөөс 257 хоногийн өмнө зогсоож байгаа нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн хууль дээдлэх зарчмыг зөрчсөн гэж үзэх үндэслэл болж байна.

“Төрийн үйл ажиллагааны шударга ёсны, ... тэгш байдлын үндсэн зарчим” гэдэг нь нийгмийн аливаа харилцаанд оролцож байна нь субъектүүдэд хууль, эрх зүйн тэгш нөхцөлийг бий болгох шаардлагыг төрд бий болгодог. Өмнөх Сонгуулийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.8 дахь хэсэгт заасан ёсоор нийслэлийн аль нэг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшихийн тулд тухайн дүүрэгт санал авах өдрөөс өмнө 180-аас доошгүй хоногийн хугацаанд тасралтгүй, байнгын оршин суугчаар бүртгүүлсэн байхыг шаарддаггүй байсан. Тэгвэл Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай шинээр батлан гаргасан хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт “дүүрэгт” гэсэн үгийг нэмснээр нийслэлийн аль нэг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвших хүсэлтэй иргэнийг тухайн дүүрэгт санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө байнга оршин суугчаар бүртгүүлсэн байх шаардлага тавьсан юм.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр батлагдаж улмаар “Төрийн мэдээлэл” сэтгүүлд хэвлэгдэн хүчин төгөлдөр болох хугацаанд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт хүчин төгөлдөр болж 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс шилжилт хөдөлгөөнийг зогсоосон. Ийнхүү шинээр батлагдсан Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасан журмын дагуу 180 хоногийн өмнө нэр дэвших хүсэлтэй иргэн тухайн дүүрэгтээ бүртгүүлэх боломжгүй болж байгаа нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дэх хэсэгт заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэл болж байна.

Дээрх тайлбар үндэслэлүүдийг харгалзан үзэж Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 9, 18 дахь заалтыг тус тус зөрчиж байгаа эсэхийг хянан дүгнэлт гаргаж өгнө үү.” гэсэн мэдээллийг ирүүлжээ.

Гурав. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

“... Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Аймаг, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн.”, Тавин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Нутгийн өөрөө удирдах байгууллага бол аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хороонд иргэдийн Нийтийн Хурал, тухайн Хурлын хуралдааны чөлөө цагт түүний Тэргүүлэгчид мөн.” гэж заасан.

“Европын улсуудын нутгийн удирдлагын тухай Харт”-ын 3 дугаар зүйлд “Нутгийн өөрөө удирдах ёс гэдэг нь нутаг дэвсгэрийн бие даасан хамтлагаас өөрийн хариуцлага дор төрийн хэргийн үлэмж хэсгийг тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа иргэдийн ашиг сонирхолд нийцүүлэн, хуулийн хүрээнд шийдвэрлэх, удирдлагыг хэрэгжүүлэх эрх, бодит чадвар юм.” гэсэн.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулиар ийнхүү нутгийн өөрөө удирдах байгууллагыг байгуулж байгаа ба түүний төлөөлөгчийг сонгож байна.

Дээр дурдсан Үндсэн хуулийн заалтууд нь иргэдийн оршин суугаа сум, аймаг зэрэг нэгжийнхээ нийт иргэний эрэлт хэрэгцээ, ашиг сонирхлыг хангахад нийцсэн бүхий л үйлчилгээг өөрсдөө шууд буюу төлөөлөх байгууллагаараа уламжлан хуулийн хүрээнд бие даан шийдвэрлэж, хариуцан гүйцэтгэх эрх, баталгааг олгож байгаа юм. Иймд энэхүү нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаанд шууд оролцон шийдвэр



гаргах эрх бүхий этгээд нь 180 ба түүнээс дээш хоног тухайн орон нутаг оршин сууснаараа тухайн орон нутгийн талаарх мэдээлэлтэй болж, шийдвэр гаргах эрхтэй болдог байх нь зөв юм.

Монгол Улсын Үндсэн хуулиар Улсын Их Хурлын гишүүн нь нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтлахаар заасан. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч төрийн хэргийг тухайн оршин суугаа иргэдийн ашиг сонирхолд нийцүүлэн, хуулийн хүрээнд шийдвэрлэх юм. Мөн Улаанбаатар хотод, эсвэл өөр газар амьдардаг ч өөр аймаг, сумын нутгийн өөрөө удирдах байгууллагад сонгогдон ажиллаж байгаа тохиолдол байдаг талаарх иргэдийн шүүмжлэл гардгийг харгалзан тухайн орон нутгийн оршин суугчдын эрх, ашиг сонирхлыг хамгаалах үүднээс Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 5.2 дахь хэсэг тусгагдсан. Тиймээс Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 5.2 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн гэж үзэх үндэсгүй байна.

Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл гаргагч иргэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг хоорондын зөрчилдөөнөөс үүдэн Үндсэн хуулиар олгогдсон эрх зөрчигдөхөд хүрснийг дурдсан. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг нь Улсын Их Хурлаар уг хуулийг хэлэлцүүлэх үед ажлын хэсгээс гарсан саналын дагуу тусгагдсан байна.” гэжээ.

ҮНДЭСЛЭЛ:

1. Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр баталж, 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс дагаж мөрдсөн Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт “18 нас хүрсэн, тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэгт санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө байнга оршин суугчаар бүртгүүлсэн, сонгуулийн эрх бүхий, энэ хуульд заасан бусад шаардлагыг хангасан иргэн тухайн шатны Хурлын Төлөөлөгчөөр сонгогдох эрхтэй.”, мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт “Орон нутгийн Хурлын ээлжит сонгуулийн санал авах өдөр нь ээлжит сонгуулийн жилийн 10 дугаар сарын эхний хагасын аль нэг ажлын өдөр байна.” гэж тус тус зааснаас үзэхэд орон нутгийн сонгуульд нэр дэвшигч иргэн нь тухайн сонгуулийн жилийн 4 дүгээр сарын эхний хагаст багтаж тухайн орон нутагтаа байнгын оршин суугчаар бүртгүүлсэн байхаар хуульчилжээ.

Харин Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт ээлжит сонгуулийн жилийн 02 дугаар сарын 01-ний өдрөөс санал авах өдрийн дараах өдөр хүртэл шилжилт хөдөлгөөнийг зогсоохоор хуульчилсан нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн

иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт заасны дагуу орон нутгийн Хуралд нэр дэвших хүсэлтэй иргэн дээрх хугацаанд тухайн орон нутагт байнга оршин суугчаар бүртгүүлж, сонгогдох эрхээ эдлэх боломжгүй болгожээ. Тодруулбал, хууль тогтоогч тус хуулийг батлахдаа түүний хэрэгжих боломж, бусад хуулийн зохицуулалт хоорондын харилцан уялдааг хангаагүйгээс Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтаар баталгаажсан иргэдийн сонгогдох эрхийг хязгаарласан гэж үзэхээр байна.

2.Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Нутгийн өөрөө удирдах байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хороонд иргэдийн Нийтийн Хурал байна. ...” гэж заагаад мөн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэх бүрэн эрхтэй байгууллага болохыг тогтоожээ.

Иймд тухайн орон нутгийн иргэдийн эрх ашиг сонирхлыг хамгаалах зорилго бүхий нутгийн өөрөө удирдах байгууллагын онцлогоос хамаарч аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд нэрээ дэвшүүлж буй этгээд тухайн орон нутагт тасралтгүй, байнга оршин суугаа байх шалгуурыг тогтоох нь үндсэн хуулийн эрх зүйн нийтлэг зохицуулалт бөгөөд ийнхүү Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт зааснаар орон нутгийн сонгуульд нэр дэвшигч иргэн 180-аас доошгүй хоногийн өмнө байнга оршин суугчаар бүртгүүлсэн байх шалгуурыг тогтоосон нь хууль тогтоогчийн бүрэн эрхэд хамаарч байх ба сонгох, сонгогдох эрхийг үл хөндсөн байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт “Иргэний засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөнийг ээлжит сонгуулийн жилийн 02 дугаар сарын 01-ний өдрөөс ... эхлэн зогсоож, санал авах өдрийн дараах өдрөөс сэргээнэ.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын “... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ...” гэснийг тус тус зөрчсөн байна.



2.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 18 дахь заалтыг зөрчөөгүй байна.

3.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалт, Арван есдүгээр зүйлийг 1 дэх хэсгийг тус тус зөрчөөгүй байна.

4.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт “ ... ээлжит сонгуулийн жилийн 02 дугаар сарын 01-ний өдрөөс, ...” гэж заасныг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

5.Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ

Д.ОДБАЯР

ГИШҮҮД

Ш.ЦОГТОО

Г.ТУУЛХҮҮ

Ш.СОЛОНГО

Ц.НАНЗАДДОРЖ

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1,5

Индекс: 200003